



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтныг
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Практикал даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Эрдэнэбаатарын Баярмагнайг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллахыг Э.Баярмагнайд үүрэг болгосугай.
3. Тогтоол батлагдсантай холбоотой Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 218 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН